

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖИЙН ХЭЛСЭН ҮГ**

Энэ хуралдаанд хүрэлцэн ирсэн та бүхэнд өдрийн мэнд дэвшүүлж байна. Монгол, Орос хоёр улс хувь заяагаараа, хил залган оршиж олон зууны туршид эвтэй найртай амьдарч ирсэн түүхтэй гэдгийг тэмдэглэж байна. Би 1975 онд Эрхүү хотын Их сургуулийн бэлтгэлийг, 1981 онд Ленинград хотын Их сургуулийн хуулийн ангийг төгссөн хүний хувиар энэ найрамдал хамтын ажиллагааны хурлыг нээх завшаан тохиосонд бас баярлаж байна.

Өнгөрсөн долоо хоногт ОХУ-ын Холбооны Зөвлөлийн дарга Миронов Монголд айлчлаад буцлаа, өнгөрсөн оны 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-д айлчлаж Москвагийн тунхаглалд гарын үсэг зурлаа. Өнөөдөр та бүхэн хамтраад 60 жилийнхээ ойг тэмдэглэж байна, энэ бол хоёр орны ард түмний харилцаа шинэ нөхцөлд улам идэвхитэй болж байгаагийн баримт гэж ойлгож байна. Монгол, Оросын ард түмний найрамдлыг бэхжүүлэхэд үеийн үед их үүрэг гүйцэтгэж ирсэн онцгой хүмүүс байдаг. Энэ хурлын ажиллагаанд ийм үүрэг гүйцэтгэсэн сансрын нисгэгч Горбатко баатар бас сансрын нисгэгч Гүррагчаа баатар хоёр оролцож байгаад их баяртай байна. Ерөнхийлөгчийн түвшинд, парламентын түвшинд, Засгийн газрын түвшинд, засгийн газрын байгууллагуудын түвшинд харилцаа муугүй байгаа, гэхдээ өнөөгийн харилцааны хүрсэн энэ түвшин хүрэх мөрөөдлийн түвшин биш гэдгийг бас хэлэх хэрэгтэй. Цаашид эдийн засгийн салбарт хамтарч ажиллах чиглэлээр, аль аль талдаа ашигтай хөрөнгө оруулалт хийх талаар, эдийн засагт хил гаалийн чиглэлд гарч байгаа бэрхшээлийг даван туулах талаар хоёр орон нэлээд идэвхитэй хамтарч ажиллаж чадвал харилцааны шинэ шинэ боломжууд, харилцааны шинэ шинэ үүд хаалгууд байна гэж ойлгогдож байна. Сүүлийн үед төрийн өндөр дээд хэмжээнд хийж байгаа уулзалтуудын учир утга, яриа хэлэлцээрийн агуулга чухам энэ тал дээр чиглэгдэж байгаа гэдгийг хэлье. Ингээд хоёр орны ард түмний харилцаанд онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн Найрамдлын нийгэмлэгийн байгууллагууд, тэдгээрийн удирдлагуудад хоёр орны ард түмний харилцааг сайн байлгахын төлөө ажил амьдралаа зориулж яваа та бүхэнд аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байна. Найрамдлын нийгэмлэгийн ажил бас энэ хурал зөвлөлгөөн амжилттай байж Монгол, Оросын ард түмний хамтын ажиллагааг сайжруулахад улам их хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Монголын ард түмэн нутагтайгаа нүүгээд явчихгүй, Оросын ард түмэн бас нутагтайгаа нүүгээд явчихгүй, ертөнц бурхан багш та биднийг зэрэгцэн амьдрах агуу их хувь заяагаар холбосон учраас энэ их хувь заяа дандаа өөдрөг, дандаа өнгөлөг, дандаа сайн сайхан харилцаагаар баяжиж байхын ерөөлийг дэвшүүлж энэ хурлын ажилд амжилт хүсч байна.